

## **“МОНГОЛ ШУУДАН” ТӨХК-ИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016 оны 01 дугаар  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Тус компани нь 2015 оны жилийн эцсийн байдлаар 11,75 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, 10,094 тэрбум төгрөгийн орлого оруулан, 85,9 %-ийн биелэлттэй ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 8,4 хувиар буурсан дүнтэй байна. Түүнчлэн компанийн зардлын төлөвлөгөө 11,075 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэй байснаас 9,976 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, төлөвлөгөөт зардлаа 10 хувиар хэмнэн ажилласан байна. Татварын дараах ашиг 94,01 сая төгрөг байна.

Компанийн хэмжээнд хэрэгжүүлэхээр зорьсон 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 91%-тай биеллээ.

Өнөөдрийн байдлаар 902 хүн ажиллаж байгаагаас хотод 378, орон нутагт 524 хүн ажиллаж байна. Нийт ажилчдыг нас, хүйсээр нь харьцуулбал эмэгтэй- 69%, эрэгтэй-31%, 24 хүртэлх насны хүн -3,9%, 25-29 насны хүн-13,8%, 30-34 насны хүн 13,8%, 35-39 насны хүн 12,2%, 40-44 насны 14,7%, 45-49 насны 20,4%, 50-54 насны 15,7%, 55 ба түүнээс дээш насны хүн-5,5%-ийг эзэлж байна.

Тайлант хугацаанд олсон амжилтаа бататгаж, компанийн орлогыг нэмэгдүүлэх, шуудангийн үйлчилгээг өргөтгөж, хүн амд ойртуулах зорилгоор өнгөрсөн хугацаанд шинээр хэрэгжүүлж эхэлсэн ажлуудыг улам сайжруулах, шинэ нэр төрлийн үйлчилгээг нэмэгдүүлэх болон ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, компанийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг шинэ шатанд гаргах, цахим технологид суурилсан тайлан, мэдээ, судалгаа гаргах, ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын эмх цэгцийг улам боловсронгуй болгох, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн дараах чиглэлээр ажиллаа.

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын чиглэлээр**

Тайлант хугацаанд хүний нөөцийн програм, цаг бүртгэлийн програм болон санхүүгийн програмыг хооронд нь холбож, уялдаа холбоог сайжруулан ажилласнаар ажилтнууд програмаас цалингийн болон цагийн мэдээллээ авах, чөлөө авах, гадуур ажлаар гарах зэрэг хүсэлтийг програмаар дамжуулан удирдлагуудад хүргэдэг болсон.

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь хагацал тохиолдсон 18 хүнд 3 сая 100 мянган төгрөгийн, нас барсан ажилтанд 500 мянган төгрөгийн, нас барсан 5 өндөр настанд 500 мянган төгрөгийн, ойр дотных нь хүн нас барсан 9 ажилтанд 1,350 мянган төгрөгийн тэтгэмж, анх удаа гэр бүл болсон 3 хүнд 1,1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал, сувиллын унааны зардалд 1 хүнд 40 мянган төгрөгийн хөнгөлөлт, хүндээр өвдсөн 2 ажилтанд 400 мянган төгрөгийн, эхнэр /нөхөр/, хүүхэд хүндээр өвдсөн 5 ажилтанд 750,0 мянгөн төгрөгийг буцалтгүй тусламж олгож, 26 ажилтанд 1 сая 620 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүллээ.

Компанийн Улаанбаатар хотын ажилчдын цалинг 04 дүгээр сарын 01-нээс эхэлж 100 мянган төгрөгөөр, аймгийн ажилчдын цалинг 07 дугаар сарын 01-нээс эхэлж 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 94 жилийн ойг тохиолдуулан, ажил үйлсээрээ тэргүүлсэн нийт 131 ажилтан ажиллагсдыг салбар болон байгууллагын шагналаар шагналаа.

Билгийн улирлын цагаан сар, шууданчдын баярыг тохиолдуулан, одоо ажиллаж байгаа болон өндөр насны тэтгэвэрт гарсан “Хүндэт шууданч” нарт 9,3 сая төгрөгийн нэмэгдэл тэтгэмж олгож, тэднийг хүлээн авахад 9,6 сая төгрөг зарцуулсан байна.

МШХХТГ-ын даргын “Ахмад настны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 04-р сарын 13-ны өдрийн 1/210 тоот зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагын өндөр настан ахмадуудын биеийн байдал, ахуй амьдралын асуудлаар холбогдох салбар нэгжийн хүмүүсээс байнга мэдээлэл авч, хүнд өвчнөөр өвдөж, хүний асаргаанд орсон 7 ахмадыг эргэж, 700 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор дотоод сайтад “Өргөдлийн булан”, mongolpost.mn сайтад авлигын эсрэг хууль, журмын булан нээж, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээллийг байршуулсан.

Ажилчдынхаа ажлын арга барил, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Орон нутгийн сургалт – 2015” гурав хоногийн сургалт семинар, шинэ ажилтны сургалт, ахисан түвшний сертификаттай сургалт, “Ажлын бүтээмжийг дээшлүүлэх сургалт”, “Хөдөлмөрийн харилцаа”, ажлын байран дээрх сургалтуудыг чанарын өндөр түвшинд зохион байгууллаа.

Архивын бүртгэлийн системийг цахимжуулах, цахим мэдээллийн санг бүрдүүлэх, архивын хадгалалтын хугацааг уртасган, хайлтын системийг ашигласнаар цаг хэмнэх зэрэг асуудлыг шийдвэрлэн ажиллаж эхлээд байна.

Улаанбаатар хотын Шуудангийн үйлчилгээний салбаруудын хадгалах хугацаа дууссан, практик ач холбогдолгүй болсон 2006-2009 оны баримт, материалуудыг акт үйлдэн газар дээр нь устгах ажлыг зохион байгуулсан. “Ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан, мөрдөж ажиллаж байна.

Системийн хэмжээнд хэвлэл захиалга онлайн хэлбэрт орсон төдийгүй нэгтгэл, тайлан болон бусад мэдээллийг өдөр тутам авах боломжтой болсон.

Өөрийн орны маркийн сурталчилгааг өргөжүүлэх үүднээс шинээр хэвлэгдсэн марк, тайлбарын хамт Германы Michel, Америкийн Scott каталогид байршуулахаар тогтмол явуулж байна. Тайлант онд цонх наагч, эсгүүр гаргагч, цаас огтлогч машиныг шинээр авч техник технологийг сайжруулан хувь болон аж ахуй нэгжийн захиалгаар цонхтой дугтуй үйлдвэрлэн гаргав. Мөн шинээр нэвтрүүлсэн үйлчилгээнүүдэд зориулан RD, EE, PO, PL, FP гэсэн баар кодыг хэвлэж салбар нэгжийн эрэлтийг ханган ажиллаж байна. Монгол маркийн музейд “Монгол Шуудан” ТӨХК-ийн гаргасан бүх анхны өдрийн дугтуй, ил захидлуудыг он цагийн дарааллаар байршуулж, тасалбар гарган иргэдэд үйлчилж эхэлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн буланг нээж, онлайнаар “Ажлын байранд галын аюулгүй байдлыг хангах”, “Ажлын байрны хөдөлмөр хамгаалал”, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагаа”, “Түгээмэл мэргэжлийн ажилтнуудын аюулгүй ажиллагаа” зэрэг давтан зааварчилгаануудыг өгч, дотоод сүлжээнд ХАБЭА-н буланг нээж ажиллагаанд оруулсан.

Төвийн 224, аймгуудын ШҮГ-ын 152, нийтдээ 376 ажиллагсдын ажилдаа ирэх, гэртээ харих замын маршрутын зураглалыг гаргуулан авч, ажлын ослын хяналт тавих боломжийг бүрдүүлсэн. Шинэ галын хор 90 ширхэг ирснийг хэлтэс, газар, алба, тасаг, цехүүдэд хуваарийн дагуу олгож, шинээр 15 галын самбарыг байршуулан ажилласан.

АНДБШХ-ны сургалтын төвийн 2015 оны тэтгэлэгт сургалтанд байгууллагаас 3 ажилтыг хамруулсан. НАЖГ-ын “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд жуулчдад явуулын шуудангийн үйлчилгээ үйлчлэх хамтын ажиллагааны санамж бичиг боловсруулж хамтран ажиллаж байна.

### **Хоёр. Маркетинг, төлөвлөлтийн ажлын чиглэлээр**

Шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, ашиглалт, дамжуулах чадварыг өргөтгөн сайжруулах зорилгоор тайлант хугацаанд “Женко Тур Бюро” ХХК-тай хамтран ажиллах саналыг хүргүүлж, шинээр ил захидал хэвлүүлэх зурагны сонголтод “Цонжин Болдог” аялал жуулчлалын цогцолбор газрын Чингисийн морьтой хөшөөний 4 төрлийн зургийг ил захидал болгон хэвлүүлэх албан эрхийг авлаа. Татварын Ерөнхий Газартай байгуулсан гэрээний дагуу татвар төлөгчдөд мэдэгдэх хуудсыг хүргүүлэх туршилтын ажлыг эхлүүлээд байна.

Автомашин ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр стандарт норм тогтоох 960009 тоот тусгай зөвшөөрөлтэй, ШУТИС-ийн “Механик инженерийн сургууль”-ийн мэргэшсэн инженерүүдийн тогтоосон ёсоор шуудан тээвэр, хүргэлтэнд ашиглагдаж буй 20 төрөл,

маркийн автомашины шатахуун зарцуулалтын нормыг тушаалаар баталгаажуулж, 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсэн.

УБЕГ-тай гэрээ байгуулж, хөдөө орон нутагт явах цахим үнэмлэх, гадаад паспорт зэргийг тусгай шуудангаар явуулах байдлаар зохион байгуулж ажилласны үр дүнд цахим үнэмлэх 1313 ширхэг, гадаад паспорт 356 ширхэг явж 10 гаруй сая төгрөгийн орлоготой ажиллаа.

Мобиком корпорацитай 5 чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг боловсруулан, баталгаажуулан, одоогийн байдлаар 3 чиглэлийн хамтын ажиллагааг эхлүүлэн ажиллаж сумдын орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүллээ. Баянзүрх дүүргийн ЗДТГ-тай гэрээ байгуулж, өргөдөл гомдлын хариуг шуудангаар хүргүүлж эхлээд байна.

ОХУ-ын нутаг дэвсгэрт тараагдах онлайн худалдааны бараа бүтээгдэхүүнийг МУ-ын нутгаар дамжин өнгөрүүлэх ажлыг хийж гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулан, Хятад улсын хамтрагч компанитай байгуулсан бөгөөд одоо боломжит хувилбар, шийдлүүд дээр ажиллаж байна.

Мобиком гар утасны төлбөрийн нэхэмжлэлийг орон нутагт болон УБ хотод хүргэж гардуулан, нийтдээ 4658 ширхэг 5687600 гаруй сая төгрөгийн орлого төвлөрүүллээ. Торгуулийн хуудас жилийн эцсийн байдлаар 463358 ширхэгийг хүлээн авч, 449547 ширхэгийг гардуулж нийт 899 сая төгрөгийн орлого орлоо. Хэвлэл захиалга дотоод 2 тэрбум төгрөгийн, гадаад 242 сая төгрөгийн, номын захиалга 127 сая төгрөгийн орлого, маркийн онлайн худалдаагаар 34 орны 289 захиалгын нийт 60,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажиллаа.

Хэвлэх болон дугтуй үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүн болох 4 төрлийн дугтуй, энэ оноос цонхтой дугтуйг хийснээр нийтдээ 608851 мянган ширхэг, анхан шатны маягт, бүтгэлийн дэвтэр 564866 мянган ширхэг, RD код 426,0 мянган ширхэгийг үйлдвэрлэж орон нутаг, Улаанбаатар хотын салбаруудын худалдаанд болон дотоодын хэрэгцээнд нийлүүлсэн.

Тайлант онд С4 дугтуй 222,7 мянган ширхэг, С5 дугтуй 225451 мянган ширхэг, С6 дугтуй 88,0 мянган ширхэг, DL дугтуй 72,7 мянган ширхэг, ил захидал 165,0 мянган ширхэг, анхан шатны маягтын нэгтгэл 564,8 мянган ширхэг RD код болон RC, EE кодууд 426,0 мянган ширхэгийг үйлдвэрлэн гаргалаа.

### **Гурав. Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, технологийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах чиглэлээр**

Сарын болон улирлын чанарын зөвлөлгөөнийг тогтмол зохион байгуулж, шуудангийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, гэнэтийн халдлагаас урьдчилан сэргийлэх, шууданг сааталгүй хүргэх заавар зөвлөмж, мэдээллийг байнга өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Хэрэглэгчийн үйлчилгээний хэсгээр 52320 лавлагаа хийгдсэнээс 1800-1613, 70078913 дугаарын утсаар 44574, орон нутгаас 3744, гадаад гарах, орох илгээмжтэй холбоотой 23282, бусад лавлагаа 7746 байлаа.

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар улс хоорондын 738 богц буюу 7346,5 кг газар шуудан, 43150 богц буюу 400125,9 кг агаарын шуудан, орон нутаг газраар 123091 богц буюу 728284,7 кг, агаараар 7605 богц буюу 67221,6 кг жинтэй шууданг солилцож хүргэсэн ба 1354156 ширхэг бичиг, боодол ялган боловсруулж, 27016 ширхэг гадаад, 27966 ширхэг дотоод илгээлт, 43708 ширхэг гадаад, 52002 ширхэг дотоод буухиа шууданг солилцлоо. Тээврийн байгууллагатай холбоотой гарсан саатал, зөрчил, шуудангийн саатлыг багасгах арга хэмжээ авч ажиллаж байна. Шуудангийн илгээмжийн хүргэлт, үйлчилгээг сайжруулах зорилгоор хүргэлтийн талбай ихтэй, алслагдсан газарт үйлчилгээ үзүүлдэг шуудангийн салбаруудад машинтай хүргэлтийг тогтмол хийж эхэллээ.

Шуудан үйлчилгээний 4 салбарт засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Шуудангийн илгээмжийн хүргэлт гардуулалтад цахим хэлбэрээр өдөр тутам тавих хяналтыг тогтмолжуулан судалгаа тайлан авч, дүн мэдээ гарган тухай бүр хариуцлага тооцож байгаагаас гадна удирдах ажилтнуудтай өдөр бүр сүлжээгээр харилцаж асуудлыг

шийдвэрлэн үйл ажиллагаанд нь хяналт тавьж байгаа нь ажил хэрэгч байдлыг дээшлүүлж, шуурхай ажиллагааг хангахад нөлөө үзүүлж байна.

Тайлант онд нийт 57 хэрэглэгчдээс өргөдөл гомдлыг хүлээн авч, хохирол барагдуулах актаар 23 хэрэглэгчийн хохирлыг барагдуулж, 31 хэрэглэгчийн өргөдөл гомдлыг цаг тухай бүрт нь хугацаа алдалгүй гадаад орнуудтай холбогдож эзэнд нь гардуулж шийдвэрлэсэн. Одоогийн байдлаар 3 хэрэглэгчийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх шатанд ажиллаж байна. Өргөдөл гаргасан нийт 23 хэрэглэгчийн, 8 хэрэглэгчийн хохирлыг УХТ-оор 929774 төгрөг, байгууллагын зардлаар 3 хэрэглэгчийн хохирол 257090 төгрөг, дахин нэг удаа ижил нэр төрлийн хаягаар илгээмж явуулах 7 хэрэглэгчийн 974115 төгрөг, ажлын хариуцлага алдсан ажилтан болон албан байгууллага 5 хэрэглэгчийн 426819 төгрөг нийт 2587798 төгрөгийн хохирол барагдуулан ажиллаа. Ажлын чанар, үр дүнг сайжруулах зорилгоор Бичиг захидлын ЯБХ “Бүтээлч ажлын 1 сар” аян, хаягийн сангаа баяжуулах зорилгоор “Сити тур” зохион байгуулсан. Ашиглалт үйлчилгээнд гарсан чанарын гологдол, гомдлыг нэгтгэн сар тутамд, ДШХ болон EMS кооперативийн шуурхай зар, мэдээг орчуулан тухай бүр нь info.mongolpost.mn сайтаар дамжуулан нийт шууданчдад мэдээлж байна.

Аймгийн төвөөс сумдад хүргэх шуудангийн хүргэлтэнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор зарим сумдын шууданчтай 7 хоног тутам, аймгийн шууданчтай өдөр тутам холбоо барьж шалган тогтмол хяналт тавьж байна.

Postnetv3 систем дээр шүүхийн мэдэгдэх хуудас хүргэлтийн гибрид програм, гардуулалтыг гар утаснаас хийх програм, компанийн удирдлагыг системийн хэмжээнд гадаад дотоод шуудан, орлого, солилцоо, чанарын мэдээ, ачаалал, хэвлэл гэх мэт бусад мэдээллүүдийг нэгтгэн харуулж үр дүнг тооцон, тодорхой арга хэмжээнүүдийг авах, системийн хэмжээнд хэвлэл захиалга онлайн хэлбэрт орсон ба нэгтгэл, тайлан бусад мэдээг өдөр тутам авах боломж сайжруулан ажилласан.

Ухаалаг шуудангийн хайрцгийг идэвхижүүлэх талаар ШҮ-ний салбаруудад байнга хэлж, гарсан алдаа бүрийг тухай бүр нь шийдвэрлүүлж байсан ба энэ онд ухаалаг шуудангийн хайрцгийг 570 ширхэг шуудангийн илгээмжээр цэнэглэснээс 601 ш гардуулагдсан.

### **Дөрөв. Дүгнэлт, зорилт**

Монгол Улсын эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан төсөвт байгууллагууд шуудан холбооны зардлаа танасан, мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийг даган, шуудангийн солилцоо буурч, уламжлалт үйлчилгээгээр олох орлого буурсан тул орчин үеийн технологийн дэвшлийг уламжлалт шуудангийн технологитой хослуулсан шинэ нэр төрлийн үйлчилгээг 2013 оноос эхэлж нэвтрүүлсэн.

Өнөөдөр бид шинээр нэвтрүүлж байгаа үйлчилгээнүүдийн програмын шийдлүүд, технологийн процессыг шат дараалалтай сайжруулж ажилласны үр дүнд шуудангийн үйлчилгээний найдвартай байдлыг үйлчлүүлэгч нарт мэдрүүлсэн томоохон ажил болсон төдийгүй орлогын шинэ эх үүсвэр бий болгож чадсан юм.

**2015 оны нийт орлогын 12%-ийг зөвхөн шинээр нэвтрүүлсэн үйлчилгээнүүд бүрдүүлж байна.**



Шинэ үйлчилгээ нэвтрүүлснээр шуудангийн үйлчилгээний хөгжилд дараах техник, технологийн дэвшил бий болж, үр өгөөжөө өгч байна. Үүнд:

- Гадаад болон дотоод шууданг интернэтийн сүлжээнд суурилсан олон улсын IPS, дотоод шуудангийн Postnet зэрэг програмуудаар дамжуулан бүртгэж, хянадаг болсон.
- Автомашины GPS, шуудан хүргэгчийн ухаалаг төхөөрөмж, ухаалаг шуудангийн хайрцагны мэдээллийг хянах, хэрэглэгчийн санал хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэдэг болсон. /Шуурхай удирлагын төв/
- Цонх наагч, эсгүүр гаргагч, цаас огтлогч 3 шинэ машин авч, гадны байгууллагаас авдаг байсан цонхтой дугтуйг өөрсдөө үйлдвэрлэдэг болсон. /DL дугтуй/
- Цаасгүй технологи нэвтэрч эхэлсэн /Цахим гардуулалт/
- Хүргэлтийг газар нутгийн байрлалаас үл хамааран, богино хугацаанд хүргэх боломж бүрдсэн. /Гибрид шуудан/
- Шуудан хүргэгчдийн аюулгүй байдлыг хангах шуудангийн чанар, хяналтын хугацаа сайжирсан /Цахим гардуулалт/
- Хүргэлтийн давтамж нэмэгдэж, албан байгууллага, айл өрхийн хаягжилтын сан шинэчлэгдэн сайжирсан. /Торгуулийн хуудас/

Бид 2016 онд хийж хэрэгжүүлж байсан ажлуудыг амжилттай үргэлжлүүлэхээс гадна дараах ажлуудыг шинээр хийхээр төлөвлөж байна. Үүнд:

#### 1. ШУУДАНГИЙН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ИДЭВХЖҮҮЛЭХ

- Шуудангийн үндсэн нэр төрлийн болон уламжлалт шуудангийн үйлчилгээг идэвхжүүлэж, жилийн дундаж өсөлтийг ханган ажиллана.

#### 2. ХҮРГЭЛТИЙН БИЗНЕСИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ

- Хүргэлтийг нэр төрлийг нэмэгдүүлнэ. /Архивын лавлагаа, үл хөдлөх хөрөнгийн болон төрөл бүрийн лавлагаа, гэрчилгээ, лицензүүдийн хүргэлт, жолооны үнэмлэх г.м/
- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд /Дүнжингарав, Баруун автовокзал, Мишээл/ шуудангийн салбар байгуулах, гарч буй бүтээгдэхүүн үйлчилгээг хаягаар хүргэх ажлыг зохион байгуулна.
- Гибрид шуудангийн үйлчилгээ, торгуулийн хуудасны хүргэлтийг орон нутагт нэвтрүүлнэ.

#### 3. ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН БИЗНЕСИЙГ НЭВТРҮҮЛЭХ, ХӨГЖҮҮЛЭХ

- Онлайн хэвлэл захиалгын бизнесийг нэвтрүүлнэ.
- Дотоод, гадаадын онлайн худалдааны сайтуудын хүргэлтийн ажлыг эхлүүлнэ.

#### 4. ЛОЖИСТИК ҮЙЛЧИЛГЭЭ

- ОХУ болон БНХАУ-ын шуудангийн байгууллагуудтай хамтран орос хятадын транзит тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

“МОНГОЛ ШУУДАН” ТӨХК